

ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Эрчим хүчний яам, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын барилга угсралтын гүйцэтгэгчээр шалгарсан “Power Construction Corporation of China”, “Power China Chengdu Engineering Corporation” компанийн түншлэлийн төлөөллүүд түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээнд гарын үсэг зурлаа. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц нь Монгол Улсын баруун бүс нутаг буюу Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн эрчим хүчний хангамжийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг урт хугацаанд баталгаажуулж, сэргээгдэх эрчим хүчийг энэ бүс нутагт хөгжүүлэх суурийг тавих өндөр ач холбогдолтой төсөл юм.

[Эх сурвалж: Эрчим хүчний яамны цахим хуудас](#)

ГАЗРЫН ДООРХ УСНЫ МОНИТОРИНГИЙН ӨГӨГДЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ БОЛОН МЕНЕЖМЕНТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН СУРГАЛТ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ



Усны газар, 2030 Усны нөөцийн бүлгийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Газрын доорх усны тогтвортой менежментийн ЮНЕСКО-ийн тэнхим, Газрын доорх усны нөөцийн үнэлгээний олон улсын төв, Цэнгэг усны хүрээлэнтэй хамтран Бээжин дэхь төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр “Монгол улсын сав газрын захиргааны мэргэжилтнүүдэд зориулсан газрын доорх усны мониторингийн өгөгдлийг боловсруулах аргачлал болон менежмент, төлөвлөлтийн сургалт”-ыг 2021 оны 9-р сарын 13-15-нд Цэнгэг усны байгаль хамгаалах төв дээр зохион байгууллаа.

[Эх сурвалж: “Усны газар”-ын албан ёсны Фэйсбүүк хуудас](#)

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ



УИХ-ын гишүүн Л. Энх-Амгалан, Л. Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б. Мөнхбаатар, Барилгын хөгжлийн төвийн захирал Ц.Амарсанаа, аймгийн ИТХ-ын дарга Г. Мөнгөнхуяг, Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, Мөрөн сумын Засаг дарга Б.Батбаяр, Төслийн удирдагч Б. Оюун нар Хөвсгөл аймгийн Мөрөн сумын шинэ Төв цэвэрлэх байгууламжийн албан ёсны нээлтэд оролцлоо. Цэвэрлэх байгууламж нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд баригдсан ба цэвэрлэгдсэн усаа ногоон байгууламж, зам талбай услахад дахин ашиглах, цэвэрлэх байгууламжаас гарч буй лагийг боловсруулж шахмал түлш гарган авах боломжтой дэвшилтэт технологитойгоороо онцлог юм.

[Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудас](#)

МОНГОЛЫН ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНООС "ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ-ОРХИГДУУЛЖ БОЛОХГҮЙ САЛБАР" ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос "Орон сууц, нийтийн аж ахуй-орхигдуулж болохгүй салбар" үйл ажиллагааг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. МОСНААҮАҮЭХ-ны дарга Б.Жавзандулам энэ үеэр "Манай салбар 2021-2022 оны халаалтын улиралд бэлэн. Жилийн дөрвөн улиралд өндөржүүлсэн бэлэн байдалд, 24 цагаар эмч, цагдаа, онцгойгийн алба хаагчидтай адил тасралтгүй ажилладаг ч цалин бага, нийгмийн хангамж муу, суралцахыг дэмждэггүй, цалингийн хэмжээ ипотекийн зээлийн шалгуурт хүрдэггүй...зэрэг ОСНААҮ-ний ажилтнуудад тулгардаг нийгмийн асуудлуудыг хөндлөө.

[Эх сурвалж: ХСУХАТАҮЗЗ-ийн цахим хуудас](#)